



Г ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Э.ЭРДЭНЭСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.10.08 №05/8245
танай 2019.09.23 -ны №1/625 -т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Гомбосүрэнгийн Жанцансамбуугийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Г.Жанцансамбуу нь төрийн албаны удирдах албаны тушаалтны сонгон шалгаруулалтад оролцоогүй, нөөцөд бүртгэлгүй байхад түүнийг нийтийн албаны удирдах албан тушаалд томилох нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсгийг зөрчих төдийгүй Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасан “олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдал” бий болох үндэслэлтэй байна.

Иймд нэр дэвшигчийг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн томилох нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Хашбаатар* X.ХАШБААТАР

